



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ САҢХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код:
АРА-2026/01/НА-СТА-ТЕЗ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Н.Алтантуяа
Утас: 7033-2860
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Аудитор Э.Нямсүрэн
Утас: 99629111
Цахим хаяг: Nyamsurene@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2026 он

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.04.20 № 174

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Архангай аймагт Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 64 дүгээр захирамжаар "Хангайн бүсийн өргөтгөсөн хурал, зөвлөгөөн", Модон барилдааны 7 дахь удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлангийн жилд 20 хөтөлбөр арга хэмжээнд 91,776.3 сая төгрөгийн санхүүжилт, эх үүсвэрийг төлөвлөснөөс 76,403.6 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 83.2 хувьтай байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Засаг дарга нь Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр 17 сайд, Монгол Улсын шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 19 гэрээний тайлант онд 867 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 96.1 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,515,150.33	42,044,272.77
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	29,724,749.21	32,987,293.72
3	АВЛАГА	5,916,393.66	5,946,790.56
4	УРЬДЧИЛГАА	10,400.00	0.00
5	БАРАА МАТЕРИАЛ	3,243,620.89	2,369,332.62
6	НӨӨЦИЙН БАРАА	544,978.75	665,848.05
7	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	75,007.82	75,007.82
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	115,695,411.69	133,749,975.37
9	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,695,411.69	133,749,975.37
10	Биет хөрөнгө	110,011,543.11	125,840,797.73
11	Биет бус хөрөнгө	5,569,828.65	6,809,275.66
12	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	114,039.93	1,099,901.98
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	155,210,562.02	175,794,248.14
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,892,435.97	14,777,279.19
15	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	680,671.27	2,634,740.19
16	Өглөг	567,108.49	2,512,465.51
17	Урьдчилж орсон орлого	113,562.78	122,274.68
18	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,211,764.7	12,142,539
19	Урт хугацаат зээл	11,211,764.7	12,142,539
20	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	143,318,126.05	161,016,968.95
21	Засгийн газрын хувь оролцоо	143,318,126.05	161,016,968.95
22	Засгийн газрын оруулсан капитал	15,558,087.91	19,355,851.2
23	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,726,494.73	5,809,961.32
24	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	11,370,520.88	11,586,924.55
25	Хуримтлагдсан үр дүн	103,618,077.94	116,204,251.47
26	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,044,944.59	8,059,980.41
27	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	155,210,562.02	175,794,248.14

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	105,505,029.93	112,529,409.12
2	ТАТВАРЫН ОРЛОГО	28,774,792.92	31,085,719.19
3	Орлогын албан татвар	23,276,708.26	24,265,777.62
4	Хувь хүний орлогын албан татвар	22,944,098.28	23,884,142.07
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,104,014.93	-1,424,926.25
6	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	9,164.40	10,189.90
7	ААН-ын орлогын албан татвар	1,427,460.51	1,796,371.91
8	Хөрөнгийн албан татвар	2,577,686.47	3,018,446.37
9	Бусад татвар, төлбөр, хураамж	2,920,398.19	3,801,495.19
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,891,982.36	81,443,689.93
11	Хөрөнгийн орлого	130,117.60	122,387.00
12	Тусламжийн орлого	0.00	5,991,406.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,838,254.65	0.00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	69,030,908.01	77,669,611.43
15	УРСГАЛ ЗАРДАЛ	64,495,855.77	75,579,789.69
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,597,842.63	69,068,315.15
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,376,523.45	24,662,040.07
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,675,347.16	3,282,716.72
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,840,992.30	13,497,572.69
20	Хангамж, бараа материалын зардал	1,860,298.26	1,833,951.45
21	Нормативт зардал	175,569.26	301,053.27
22	Эд хогшил, урсгал засварын зардал	2,056,840.64	2,302,376.75
23	Томилолт, зочны зардал	446,290.20	535,626.70
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,354,749.71	9,286,310.82
25	Бараа үйлчилгээний бусад зардал	15,811,231.64	13,366,666.68
26	ТАТААС	470,366.30	2,085,895.10
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,427,646.84	4,425,579.44
28	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,535,052.24	2,089,821.74
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	36,474,121.92	34,859,797.69
30	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,796,472.68	33,777,447.51
31	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-24,796,472.68	-33,777,447.51
32	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	11,677,649.23	1,082,350.18

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	95,407,813.58	94,563,928.22
2	ТАТВАРЫН ОРЛОГО	28,774,792.92	31,085,719.19
3	Орлогын албан татвар	23,276,708.26	24,265,777.62
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,104,014.93	-1,424,926.25
5	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	9,164.40	10,189.9
6	ААН-ын орлогын албан татвар	1,427,460.51	1,796,371.91
7	Хөрөнгийн албан татвар	2,579,060.77	3,018,446.37
8	Бусад татвар, төлбөр, хураамж	2,919,023.89	3,801,495.19
9	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,053,839.74	1,008,242.55
10	Газрын төлбөр	626,701.34	989,592.30
11	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,238,482.81	1,803,660.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,782,524.39	63,478,209.03
13	Нийтлэг татварын бус орлого	16,634,140.79	15,400,887.8
14	Хөрөнгийн орлого	130,117.60	122,387.00
15	Тусламжийн орлого	0.00	4,479,144.71
16	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	46,018,266.00	43,475,789.50
17	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,850,496.27	0.00
18	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,590,711.57	64,345,706.34
19	УРСГАЛ ЗАРДАЛ	58,590,711.57	64,345,706.34
20	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,661,265.38	59,393,956.57
21	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,388,017.33	27,202,867.57
22	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,956,838.34	3,426,571.07
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,243,711.61	14,061,723.43
24	Хангамж, бараа материалын зардал	2,254,002.68	2,586,276.65
25	Нормативт зардал	68,704.84	75,391.71
26	Эд хогшил, урсгал засварын зардал	2,029,581.46	2,304,644.61
27	Томилолт, зочны зардал	435,227.80	504,753.90
28	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,268,414.37	3,932,433.06
29	Бараа үйлчилгээний бусад зардал	8,016,766.95	5,299,294.57
30	ТАТААС	472,957.86	510,321.10
31	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,456,488.33	4,441,428.67
32	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,817,102.01	30,218,221.88
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	25,290,480.66	25,423,977.38
34	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,290,480.66	25,423,977.38
35	Дотоод эх үүсвэрээр	25,290,480.66	25,423,977.38

36	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-25,290,480.66	-25,423,977.38
37	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,036,060.51	1,531,700.00
38	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,036,060.51	-1,531,700.00
39	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,490,560.83	3,262,544.50
40	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,234,188.38	29,724,749.21
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,724,749.21	32,987,293.72

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,537,245.27	125,537,245.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	109,388.46	109,388.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,646,633.73	125,646,633.73
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,582.41	-1,582.41
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-144,156.09	-144,156.09
6	Өмчид гарсан өөрчлөлт	6,139,581.59	6,139,581.59
7	Тайлант үеийн үр дүн	11,677,649.23	11,677,649.23
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,318,126.05	143,318,126.05
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	143,318,126.05	143,318,126.05
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-884,503.41	-884,503.41
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	142,433,622.64	142,433,622.64
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-12,489.4	-12,489.4
13	Өмчид гарсан өөрчлөлт	17,513,485.53	17,513,485.53
14	Тайлант үеийн үр дүн	1,082,350.18	1,082,350.18
15	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,016,968.95	161,016,968.95

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	75,768,603.00	84,720,899.24
2	Татварын орлого	25,877,276.40	31,085,719.19
3	Орлогын албан татвар	21,229,692.10	24,265,777.62
3.1	Хувь хүний орлогын албан татвар	21,022,000.00	23,884,142.07
3.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,472,000.00	-1,424,926.25
3.3	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	9,692.10	10,189.90
3.4	ААН-ын орлогын албан татвар	1,670,000.00	1,796,371.91
4	Хөрөнгийн албан татвар	2,926,115.00	3,018,446.37
5	Бусад татвар, төлбөр, хураамж	1,721,469.30	3,801,495.19
6	Татварын бус орлого	49,891,326.60	53,635,180.05
7	Нийтлэг татварын бус орлого	6,283,283.40	10,037,003.60
8	Хөрөнгийн орлого	15,000.00	122,387.00
9	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	43,593,043.20	43,475,789.50
9.1	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	9,698,399.70	9,581,146.00
9.2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	33,894,643.50	33,894,643.50
10	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,776,334.50	76,403,587.62
11	УРСГАЛ ЗАРДАЛ	64,323,895.90	56,537,951.26
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,363,570.20	51,713,976.50
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,744,025.80	23,361,790.01
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,108,923.80	2,904,649.60
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,327,195.10	13,177,964.73
16	Хангамж, бараа материалын зардал	1,747,355.80	1,321,255.02
17	Норматив зардал	55,067.90	29,504.98
18	Эд хогшил, урсгал засварын зардал	3,185,742.60	2,732,179.03
19	Томилолт, зочны зардал	564,424.70	471,569.90
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,669,452.90	2,818,520.91
21	Бараа үйлчилгээний бусад зардал	5,961,381.60	4,896,542.33
22	ТАТААС	2,086,515.80	2,086,215.2
23	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,997,298.40	1,997,298.40
25	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	89,217.40	88,916.80
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,873,809.90	2,737,759.56
27	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,639,822.60	1,773,171.57
28	Бусад урсгал шилжүүлэг	1,233,987.30	964,587.99
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,201,665.60	18,333,936.36
30	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,250,773.00	1,531,700.00
31	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-16,007,731.50	8,317,311.62

37	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,007,731.50	-8,317,311.62
38	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	20,148,330.86
39	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	28,465,642.48

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,001,861.21
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,001,861.21
6	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	55,016.80
7	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,197.45
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	963,856.27
9	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,632,790.69
10	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,785,166.89
11	УРСГАЛ ЗАРДАЛ	999,504.90
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	999,504.90
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,099.17
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,861.41
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,700.00
19	Хангамж, бараа материалын зардал	62,862.40
25	Нормативт зардал	2,499.71
27	Эд хогшил, урсгал засварын зардал	48,709.78
30	Томилолт, зочны зардал	13,500.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,813.43
35	Бараа үйлчилгээний бусад зардал	582,459.01
38	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	785,661.98
39	Дотоод эх үүсвэрээр	785,661.98
43	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,216,694.32
44	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,216,694.32)
45	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,216,694.32)

3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **3,396.7** сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

- Санхүүгийн нэгтгэсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд "Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ-ын түрээслэгчийн барьцаа 12.7 сая төгрөгийн мөнгөн орлогыг хөрөнгө оруулалтын мөнгөн орлогод бүртгэж, тайлагнасныг аудитын явцад залруулав.
- Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын авлагын насжилтыг судалгаагаар тулган шалгахад Finperform системд 0-1 жилийн насжилттай авлагын дүн 1,025.4 сая төгрөг, 4-5 жилийн насжилттай авлага 666.6 сая төгрөгөөр илүү, 1-2 жилийн насжилттай авлага 338.9 сая төгрөг, 2-3 жилийн насжилттай авлага 35.9 сая төгрөг, 3-4 жилийн насжилттай авлага 921.6 сая төгрөгөөр дутуу, нийт 3,383.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 878.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн 189.7 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагууд /"Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан 9 ТШЗ-ийн, 12 ТТЗ-ийн, 5 ОНӨҮГ-ын зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт 689.2 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг гэж үнэлснээр нийт материаллаг зөрчлийн дүн **878.9** сая төгрөг болсон. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүн **1,114.4** сая төгрөгийн түвшнээс бага байх тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийг хүргүүлээ.*

4.1 АЛБАН ШААРДЛАГА

4.1.1. Аймгийн "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 20 дугаар тогтоолоор татан буулган шийдвэр гарсан боловч цагдаа хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа шалтгаанаар аймгийн ТЕЗ-ийн тайланд 189.7 сая төгрөгийн хөрөнгийн дүн нэгтгэгдэж, татан буулгах арга хэмжээ аваагүй, дуусгалтын тайланг бэлтгэж холбогдох арга хэмжээг аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т "Татан буулгах хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого хийж дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн энэ хуулийн 30 дугаар зүйлд зааснаар бусдад шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг ... шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ", 78.1-д "... иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг ... хэрэгжүүлэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ-ын өмч хөрөнгө, өр авлагыг эцэслэн шийдвэрлэж, дуусгалтын тайланг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх, татан буулгах талаар холбогдох арга хэмжээг авч, үр дүнг тайлагнах албан шаардлагыг хүргүүлээ.

4.1.2. "Архангайн ус суваг", "Тунгалаг тамир цогцолбор", Эрдэнэмандал сумын "Хөгжлийн дэд бүтэц", Хайрхан сумын "Хөгжлийн дэд бүтэц", "Чулуут ахуй үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ууд нь аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авч, тайлант онд алдагдалтай, өр, авлага үүсгэж ажилласан бөгөөд үүнээс аймгийн ТЕЗ-ийн тайланд үзүүлэх нөлөөллийг тооцож үзэхэд 154.5 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэллээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 20.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж

заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг үр ашигтай, үр дүнтэй ажиллуулах, төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж байгаа бизнес төлөвлөгөөг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг хангуулах, удирдлага менежментийн зөв бодлого хэрэгжүүлж, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд шат шатны хяналтыг тавьж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

5.1 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

5.2.1. ДОТООД АУДИТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2,883.0 сая төгрөгийн алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийгдэж, 3,842.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн бөгөөд аймгийн ТЕЗ-ийн тайланд 534.7 сая төгрөгийн зөрчлийг материаллаг зөрчил нэгтгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын алдаа зөрчлийг бууруулахад анхаарч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн жилд нь дотоод аудитыг хэрэгжүүлж, зөвлөн туслах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 05 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

-----oOo-----

